



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн шинэчлэн
байгуулах тухай

Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Ёс зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Дарга:

- Бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Энх-Амар

Гишүүд:

- Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Д.Ариунбаяр
- Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн М.Ариунболд
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Д.Батмөнх

Нарийн бичгийн дарга:


- Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн М.Чулуунцэцэг

2. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалган тогтоож, дүгнэлт гаргаж ажиллахыг Ёс зүйн хороо /М.Энх-Амар/-нд даалгасугай.

00000002

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Ёс зүйн хороо байгуулах тухай” Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЭНХБАТ